



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/379

Алтай хот

Хантайшир уулын аймгийн 100 жилийн  
түүхэн ойн тохижилт, бэлтгэл ажил хангах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны "Зарим аймаг байгуулагдсаны ойг тэмдэглэх болон баяр наадмын хугацааг тогтоох тухай" 221 дүгээр тогтоол, "аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай" 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хантайшир уулын аймгийн 100 жилийн түүхэн ойг тэмдэглэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж Есөнбулаг сумын 10 багт нийтийн бие засах байгууламжийн тоог нэмэгдүүлж, хэвийн ашиглалт, үйлчилгээг хариуцан ажиллахыг "Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Э.Энхболд)-т даалгасугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 250,000,000 (хоёр зуун тавин сая) төгрөгийг орон нутгийн төсвийн урсгал зардалд батлагдсан Хантайшир уулын аймгийн 100 жилийн түүхэн ой, тохижилтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг "Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (Э.Энхболд)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

0201000376